

ОЙРХИ ДОРНОДЫН ТАЛААР ЯВУУЛСАН МОНГОЛЫН ГАДААД БОДЛОГО (XIII-XIV ЗУУН)

С.Оюунсүрэн*

Монгол гүрний гадаад бодлого, дипломат ажиллагаа эе эвийг хичээхээс зэвсгийн хүчээр номхотгох зарчмын дагуу явагдаж Евразийн өргөн уудам газар нутгийг бараглан өөрийн гарт оруулж, монгол туургатны харьяанд багтаагаад дэлхийн хэмжээний нэгдмэл нэг улс байгуулсан нь ерөөс бусдыг эзлэн түрэмгийлэх, дарангуйлан ноёлох гэсэн зорилт байгаагүй юм. Харин ч нийт хүн төрөлхтнийг нэгэн төрийн захиргаан дор, нэгэн гэрийн дээвэр дор эвсэг нэгдмэл аж төрөн суухыг зорьсон агаад тийнхүү Богд Чингис хаан нэгэн насныхаа үйлийг бараглан гүйцээж урьд хожид дэлхийн улс төрийн тавцан дээр энгүй ихийг байгуулсныг хожмын олон мэргэд судлан шинжилсээр, үнэлж дүгнэсээр байдаг билээ. Чингис хааны байгуулсан энэ их улсын нийгмийн байдлыг зарим судлаачид *"Pax Mongolica"* буюу *"Монгол маягийн энх тайван"* гэж нэрлэсэн байдаг.

Чингис хаан болон түүний залгамжлагчдын дээдлэн хатуу чанд сахиж ирсэн "Их Засаг" хуульд эзлэн авсан улс гүрний ард түмний соёл иргэншил, аж ахуй, амьдралын хэв маяг, уламжлал, зан заншлыг эрхэмлэн үзэхийн зэрэгцээ хүний шүтэж бишрэх эрхийг онцгойлон "Аль нэгийг нь илүүтэйд үл үзэн бүх шашин шүтлэгийг хүндэлж байхыг" заасан нь Лалын шашин дундад зуунаас Монгол нутагт дэлгэрч, тус орны нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлого, оюун санааны амьдралд нөлөөлөх эрх зүйн нөхцлийг бүрдүүлж өгсөн. Иймээс ч Монголын эзэнт гүрний их хаад, язгууртнууд эртнээс худалдаа, наймааны арвин туршлагатай Ойрхи дорнод, Төв Азийн лал шашинтнуудыг ивээлдээ авч итгэл хүлээлгэн санхүү болон улс төрийн хэрэгт өргөнөөр ашиглаж байсан нь харагддаг.

* МУИС, ОУХС-ийн докторант

Түүнчлэн Гильом де Рубрук¹ бээр Мөнх хааны үеийг хамарсан “Монголын эзэнт гүрэнд зорчсон нь” бүтээлдээ олон үндэстэн хийгээд олон шашинтнууд суурьших нийслэл Хархорумын худалдаачдын хорооллыг лал шашинтнууд бүрдүүлж байсан, ... дипломат ажлаар ирсэн элч нарын дунд Багдадын халифын, Рүмийн (Туркийн) султаны элчис тварсныг дурьдаад тэнд будда, лалын, христийн сүмүүд үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулж байсныг тодорхой өгүүлсэн байдаг. Энэ бол гадаад харилцаагаа эв, энхийн журмаар хөгжүүлэх чухал алхам, уран ухаан, урлаг мөн байв. XIII-XIV зууны үед эртний уламжлалтай өртөөний алба маш нарийн зохион байгуулалтай, өргөн хүрээтэй төрийн албаны том байгууллага болж хөгжин Юань гүрэн төрийн болон худалдааны бодлогоо алс орно, дорно, европ, бага ази, араб улс орнуудад хуурай болон усан замаар² журамлан явуулж байв. Ингэж Монголчууд олон улсын хэмжээнд улс төр, нийгмийн харилцаа, худалдаа, эдийн засгийн сэтгэлгээгээр давамгайлан томоохон өөрчлөлтийг хийж чадсан билээ.

XIII зуунд Египед, Сири, Византи, Киликийн (Бага) Армен, Сельжүк улс, Трапезунт болон бусад жижиг улсууд тухайн үеийн дэлхийн их бодлогын эргүүлгийн төвд татагдан оржээ. Энэ нь Дорно зүгээс Монголын байлдан дагуулагчид, Баруун зүгээс загалмайтны цэргүүд давшиж, тэдний ашиг сонирхол энэ бүс нутагт огтлолцож байснаар тайлбарлагдана. Чингис хааны үед 1219-1223 онуудад Сүбээдэйн удирдлага дор Монгол цэргийн магнай ангиуд Ойрхи Дорнодын бүс нутаг уруу цөмрөн орж байсан бол Мөнх хааны үед Хүлэгү жанжны цэрэг Ирак, Сири, Палестиний газар нутгаар давшин Африк тивийн босгонд тулж очсон билээ. Гэвч энэ үед тэднийг эсэргүүцэн тэмцэж ялсан цорын ганц хүч бол Египедийн мамлюк³ууд байсан юм.

Ийм нөхцөлд цааш давшилт хийх боломжгүй болсноор Хүлэгү Иранд Монголын тав дахь хүчирхэг Ил хаадын улс⁴ыг байгуулсан нь Египедэд⁵ эзлэгдэх аюулыг авчирсан.

¹ Франкын элч, санваартан тэрбээр 1254 онд Монголын нийслэл Хархорум хотноо ирж Мөнх хаантай уулзаж байв.

² Хубилай хааны цэрэг Өмнөд Сүн улсыг бүрмөсөн эзлэн авч (1279 оноос хойш), зүүн болоод өмнө чиглэлээр их далайд гарах гарцтай болсон тэр үеэс усан замын өртөөг зохион байгуулах болсон гэж үзмээр байна.

³ Мамлюкууд нь МЭ1250-1517 онуудад Египедийг захирч байсан цэргийн бүлэглэл юм. Тэдний уг гарал Турк, Монгол, Черкес боолчууд ба 1100 оны сүүл үеэр Египедэд Хар тэнгисийн хойд хэсгээс анх худалдагдан авчрагдсан бөгөөд Мамлюк гэсэн араб нэр томъёо нь боол (эзэмшүүлэгч) гэсэн утгатай юм. Мамлюкууд эхлээд цэргийн сургуулид хамрагдаж улмаар өндөр зэрэглэлийн армид болон улсын харуул хамгаалалтанд шилжиж эцэст нь Египед улсыг хамгаалах аян дайнд оролцдог байжээ. Мамлюкууд нэгэн үе Палестин, Сири, Бага Ази (одоогийн Турк)-д ноёрхолоо тогтоож байжээ.

⁴ 1261 онд Хубилай хаан нь Иран, одоогийн Афганистан (Балх мужаас бусад), Ираны Азербайжан, Ирак Багдадын хамт, Арран, Ширван, Курдистан, Жезира, Рүмийн-Бага Азийн баруун хэсгийг Кызыл-Ирмак гол хүртэлх газрын захирагч нь Хүлэгү гэдгийг хүлээн зөвшөөрч түүнд “ил хан” цолыг хүртээсэн юм. Иймээс Хүлэгүгийн улс эсвэл Ил хаадын улс гэж түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Улмаар Монголын эзэнт гүрний гадаад харилцааг Төв Дорнод, Ойрхи Дорнод, Баруун Европт баяжуулан өргөжүүлсэн билээ. Нөгөө талаас ингэж шинэ Монгол улс байгуулагдсан үеэс Ил хаадын мэдэлд байсан газарзүйн байрлал, байгалийн баялаг, цаг уурын онцгой тааламжтай Арран болон Азербайжаныг эзэмших Алтан Ордны улс⁶ын эрх баригчдын чармайлт; Лалын шашныг сүсэглэгч бүхний хамгаалагч гэж өөрийгөө зарласан лал шашинт Бэрхийн хэнээрхэл гэх мэтийн шалтгаанаар үүдсэн Зүчийнхэн болон Хүлэгүгийнхний хоорондын өвөр зуураа дайсагнасан 40 жилийн тэмцэл эхэлсэн юм.

Чингисийн угсааны хоёр улсын хоорондын үл ойлголцох энэ байдлыг Мамлюк султад ихэд сайшаан Алтан Ордны улстай харилцаа тогтоох санаачилга ёс мэт Египедээс гарч соёл болон түүхэн хөгжлийн замналаараа адилгүй хоёр улсын хооронд XIII зууны дунд үеэс (1261 он) XIV зууныг дуустал (1395 он) найрамдалт харилцаа тогтсон билээ. Энэ нөхцөл байдлаас үүдэн Ил хаад нь улсынхаа тусгаар тогнолоо хамгаалан Мамлюкууд, Алтан Ордныхны эсрэг хоёр фронт дээр тэмцэхдээ Юань гүрэнтэй нягт холбоотой байж гадаад бодлогоо:

- Ойрхи дорнодын Антиохын ванлиг улс, Триполийн гүнлиг, Иерусалимын вант улсын загалмайтнуудтай ойртон улмаар Баруун Европын христосын шашинт улсууд Генуя, Франц, Английн хаад, Ромын паптай холбоо тогтоож элч солилцон ариун газрын төлөөх загалмайтны аянаар эхэлсэн Лалын шашинтны эсрэг тэдний тэмцлийг ихэд өдөөн хамсаатнаа болгоход;
- Рүмийн (Сельжүк) улс, Гүрж, Киликийн Армен зэрэг дагуул улсуудаар албан татвар төлүүлэх, туслах цэргийн ангиудаар хангуулахад;
- Бүс нутаг дахь эсрэг хоёр хүчний аль алинд төвийг сахисан бодлого баримталж байсан Византи Улстай сайн харилцаатай байхад чиглүүлэх болов.

Ингэж Бага Ази, Ойрхи Дорнодын улс орнууд Монголын гадаад бодлогын номлол, дипломат харилцааны ёс заншлын хүчтэй нөлөөнд оржээ.

1260 онд эхэлж 60-аад жилийн дараа өндөрлөсөн Египедийн Мамлюкууд болон Ил хаадын Монголчуудын хоорондын дайн нь Ойрхи Дорнод болон Газрын Дундад тэнгисийн бүс нутаг дахь түүхэн чухал үйл явдал байсан төдийгүй Ази, Европ хоёрын өргөн уудам нутаг дэвсгэрийг ч хамарсан билээ. Хоёр голлон тоглогч буюу Ираны

⁵ Тухайн үед эдийн засгийн хувьд арай хүчирхэг байсан Египед улс Сирийг эрхшээлдээ оруулж палестинийг эзлэн авсныхаа дараа Өрнө, Дорныг холбосон худалдааны дамжин өнгөрөх төв болсон байв.

⁶ Хар тэнгисийн хойд хэсэгт оршин тогтнож байсан Монгол улс бөгөөд түүхэнд Алтан Ордны улс буюу Зүчийн улс гэж тэмдэглэгдэн үлджээ.

Монголчууд, түүний эргэн тойрны улс орнууд болон Египед, Сирийн мамлюкуудын цэрэгжсэн нийгэм хоёроос гадна бусад оролцогч талууд буюу византичууд, левантын франкууд, италийн хот улсууд, Европын хүчнүүд (ромын хутагт ламыг оролцуулан), умар болон дорно зүгийн Монгол улсууд буюу Алтан Ордны улс, Цагаадайн улс, мөн Их хааны захирсан Юан улс ч оролцож байв. Зарим талаар үүнийг эртний “дэлхийн дайн” байсан гэж үзэж болох ажээ.

Илхаадын эсрэг тэмцэх явцдаа Мамлюкууд нь өрсөлдөгч Монголчуудаас өөрсдийгөө ямагт доогуур тавьж бүхий л нөөц, цаг хугацаа болон чадлаа хил хязгаарын цайзуудыг бэхжүүлэн хамгаалах, тагнуулын сүлжээгээ боловсронгуй болгох, мөн тэдний цэргийн сургуулилалт, түүнийг өргөжүүлэн ихэсгэх зэрэгт зориулж байсан болон Монголчуудын дайралт довтолгооны тухай мэдээллийг дөнгөж авмагц мамлюкууд өргөн хэмжээний цэргийн дайчилгаа явуулдаг байснаас үзэхэд тэд Монгол цэргүүдийн гоц чадвараас сүрхий эмээж, түүнийг нь ихэд анхаарч байсныг харуулж байна. Мамлюкийн Египед улсад шуудангийн албыг, өөрөөр хэлбэл өртөөний албыг⁷ султан аль-Малик аз-Захир Байбарс шинэчлэн сэргээж, түүнийг улс төр болон цэргийн ач холбогдолтой болгож чадсан нь улсынхаа аюулгүй байдлыг хамгаалахад ихээхэн тустай байв.

Энэ хугацаанд монголчууд хэд хэдэн удаа Сирийг эзлэх оролдлого үйлдсэн нь 1260, 1281, 1299, 1300, 1303, 1312 оны тулалдаанууд байв. Монголын хан хөвгүүдээс лалын шашинд хамгийн түрүүнд орсон Алтан Ордны улсын эзэн Бэрх мамлюкуудын холбоотон болж Хүлэгүгийн ар хударгаас довтолж монгол эрсийг бие биенийхээ өөдөөс сэлэм далайхад хүргэсэн. Хүлэгүгийн улс оршин тогтносон бүхий л үеийнхээ турш өөрийн өргөн уудам нутаг дэвсгэрийн хил хязгаарыг Алтан Ордны улсын (мөн Хорасан дахь Цагаадайнхны улсын) халдан довтолгооноос хамгаалах шаардлагатай байснаас олон фронт дээр нэгэн зэрэг дайтах хангалттай цэргийн хүч тэдэнд байсангүй. Тиймээс ч Мамлюкын дайн Илхаадын улсын хувьд хоёрдугаар зэргийн ач холбогдолтой үйл явдал

⁷ Түүний үед шуудан харилцаа маш нарийн ажиллаж, алслагдсан бүх газар нутгийг хамруулан улсын нийслэлтэйгээ холбож өгч байжээ. Нэг нэгнээсээ тодорхой зайнд алслагдан байрлах шуудангийн өртөөнд улсын шууданг зөөвөрлөх элч нарт (баридууд) зориулагдсан тусгай морьд байлгах бөгөөд зарим тохиолдолд “барид” нэр томъёогоор 2-3 фарс буюу 12-20 км-ын хооронд хэлбэлзэх шуудангийн өртөөдийн хоорондын зайг нэрлэдэг байв. Шуудангийн элч заавал зэс, зарим үед алтаар хийсэн алганы чинээ хэмжээтэй пайз авч явах ёстой ажээ. Түүний нэг талд нь: “Аллахаас өөр бурхан байхгүй, Мухаммед бол түүний лүндэн буулгагч. Буруу номтны эсэргүүцлийг үл хайхран бусад шажнуудыг ялан дийлж, үнэн шашныг тогтоох бошго зарлигаар түүнийг Аллах илгээсэн билээ” гэсэн байдаг байв. Нөгөө тал дээр нь хаанчилж буй эзэн захирагчийн цол хэргэмийг сийлдэг байв. Элч энэ пайзаа шар торгон ороолтонд ороон зангидаж, хүзүүндээ зүүж явдаг байжээ. Зарим эрдэмтэд тэрбээр монголчуудаас санаа авч морин өртөөг байгуулсан гэсэн байдаг.

болж хувирснаар монголчуудын баримталж байсан бодлого нь хилийн байлдаанаар өрсөлдөгчөө зүдрээхэд л голлох болов.

Ерөнхийдөө шийдвэрлэх томоохон тулалдаануудын завсар үед зах хязгаарын нутаг уруу харилцан довтолцох довтолгоо, дипломат тэмцлийн аргууд, тагнуулын болон бусад башир аргууд, үзэл суртлын дайн, сэтгэлзүйн тэмцэл, дагуул түшмэд улсуудаа ашиглах, дайсныхаа эсрэг цэргийн эвсэл байгуулах хэлбэрээр Мамлюкууд, Ил хаадын тэмцэл зогсолтгүй явагдаж байгаад эцэст нь Монголчуудын санаачилгаар 1323 онд энхийн гэрээ байгуулагдсан билээ. Иймээс султан 1323 онд Алтан Ордны улсын хан Үзбект илгээсэн захидалдаа: “Би ил хан Абу Саидыг сайд түшмэдийнхээ хамт үнэн шашинд орсны” нь хувьд лалын шашны төлөө найрамдал тогтоосон бөгөөд түүнд Меккад мөргөл үйлдэхийг хориглож болохгүй, тэрбээр лалын нэг тулгуур болж, сүжиг бишрэлийн ялалт хийгээд энх тайвны хамсаатан болох буй за ...” гэсэн байдаг.

Дээрээс харахад Ил хан Хүлэгү болон түүнийг залгамжлагчид тухайн үеийн улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс нөхцөл байдалд тохируулан шашинд янз бүрээр хандаж байв. Хүлэгү, Абага, Аргун хааны үед гадаад бодлогын улмаас зайлшгүй христос шашныг дэмжин, тэдний дунд нэр хүнд олж авах хэрэгтэй байсан бол Газан, Өлзийт султаны үед ноёрхлоо хэвээр хадгалах зорилгын үүднээс нутаг орны ард олны санал сэтгэлийг татах, гол нь Ираны ихэс дээдэс язгууртнуудын эрх ашигтай зохицохын тулд лалын шашинд орж түүнийг төрийн шашин болгон зарлаж байсан юм.

Монгол хаад харьцангуй цөөн тооны байлдааны хүчээр бүр Чингис хааны үед гаргасан тийм чадамгай, уян хатан цэрэг дайны зохион байгуулалтыг хэрэгжүүлж, засаг захиргаанд туслуулахаар өөрсдийн соёлын зөвлөхүүдээ хамт авч явдаг байв. Ил хаад эхнээсээ л эзлэгдсэн улс орнуудын шажны номлолд таатай хандаж улмаар өөрсдийн материаллаг ашиг сонирхлоосоо шалтгаалан хотын амьдрал, үйлдвэр, худалдааг сэргээн босгох талаар анхаарч улмаар амьдралд зайлшгүй анагаах ухаан, математик, одон орон зэрэг шинжлэх ухааны салбаруудыг ихэд чухалчилдаг байсан. Чингис хааны ач Персийг эзлэгч ил хан Хүлэгү одон орон судлаач Насир-ад-динд зориулан Мераг хотод (Азербайжаны) тухайн үеийн шилдэг төхөөрөмжүүдээр тоноглогдсон Туси одон орны оргилыг барьж өгчээ. Чингис хаан нас барсны дараагийн 10 жилд татвар, гувчуурыг эд бараа авах замаар гүйцэтгүүлдэг байсан бол түүний ач гуч нарын үед мөнгөний системд бүрэн шилжин орсон. Хотууд зөвхөн сэргээн босгогдоод зогсоогүй, улмаар Тебриз, Тегераны дунд баригдсан Султания гэх мэт шинээр хотууд баригдаж зөвхөн монголчуудын

үед том, баян хот болсон Азербайжаны гол хот Тебриз нь персийн хуучин хотуудын аль нь ч гүйцэхээргүй болжээ. XIV зууны Монголын хаадын үед персийн уран барилгын цаашдын амжилтыг харуулсан олон сайхан барилгууд баригдсанаас дурьдахад Султанид байрладаг Өлзийт (1304-1316) ханд зориулсан лалын сүм, Верамин дахь (Тегеранаас зүүн тийш) түүний хүү Абу Сайдын (1316-1335) лалын сүмүүдийг нэрлэж болно.

Монголын их гүрэн нь Алс болон Ойрхи Дорнодын соёлт улс орнуудыг өөрийн захиргаанд нэгтгэсэн нь худалдаа болон соёлын үнэт зүйлсийн солилцоонд сайнаар нөлөөлжээ. Энэ нь өмнөд Ази, Хятадын хоорондох жингийн худалдаанд урьд өмнө болон хожмын үед ч байгаагүй тийм агуу хөгжил дэвшилд хүргэжээ. Их гүрэн хэд хэдэн улс болон задрахад Чингис хааны удмынхан захирдаг Перс болон Хятад дахь монгол улсуудын хооронд нягт нарийн харилцаа холбоо хэвээр хадгалагдан үлдсэн. Үүнээс гадна Египедийн лал шашинтнуудад санасан өс хонзон нь персийг эзэмшигч монголчууд болон европчуудын хувьд адил байсан тул тэднийг ойртуулжээ. Үүгээр Европын худалдаачид болон шажин номлогчид Дундад Азиар дамжих өртөө замаар төдийгүй Персийн боомтоос Энэтхэг Хятад уруу хүрэх усан замыг ашиглах боломжтой болсон билээ. XIII зуунаас ажиглагдах болсон соёлын дэвшилт бол худалдааны харилцаа холбооны үр дүн мөн бөгөөд тэр үед соёлын анхдагч нь мусульманы ертөнцөд, тэр дундаа Персид хамаардаг байв. Хэрэв персийн ард түмэн соёлын түүхэн цаг үеийн ямар нэгэн үед дэлхийн соёлын хэрэгт эргэлзээгүй нэгдүгээр байр эзэлж байсан бол тэр нь яг энэ Монголын эзэрхийллийн үе юм.

Марко Поло өөрийн үзэж харсан Хятадын газар нутгуудийн олон газар зүйн нэрсийг яг перс хэлбэрээр нь бичжээ. Хятадын одон орон судлаачид XIII зуунаас Персид үзэгдэх болж улмаар Персийн одон орон судлаачдын Хятад дахь өгөөжтэй үйл ажиллагааны дүнд тус улсын одон орны шинжлэх ухаан нь бүхэлдээ тэдний нөлөөлөлд автсан байв. Византид Персийн одон орны бүтээлүүд XIV зууны үед грек хэл үрүү орчуулагдаж байв. Персийн нутагт ноёрхогч Ил хаадын Монголчуудын олон шинэ дэвшилтэт санаачлагын нэг нь улсынхаа бүрэлдэхүүнд багтаж байсан бүх ард түмэн, харилцаатай байсан Хятадаас эхлээд Франц хүртэлх (баруун европчууд) улс орнуудын түүхэн үйл явдал, домгийг эмхтгэн гаргах ажил байсан. Энэ чухал үүргийг Еврей гаралтай лалын шашинт Рашид ад-Динд хариуцуулан хамтрагчаар нь Хятадын хоёр эрдэмтэн, Кашмирын буддын лам, Персийн эрдэмтэд, Францын монах нарыг оролцуулсан ажээ. Энэ бүтээл нь ард түмний домог болон, түүхэн үйл явдлыг нэмж хасалгүй, мөн үнэлгээ дүгнэлт өгөлгүйгээр бодит байдлаар тусгасан өргөн цар хүрээг хамарсан өгүүлэмжтэй тул дэлхийн

утга зохиолын хүрээнд чухал байр суурь эзэлдэг. Үүнээс өмнө, хойно хуучин ертөнцийн болвсролтой эрдэмтэн мэргэдийн ухаанаар бүтээгдсэн дэлхийн түүх нэг ч байгаагүй билээ.

Ер нь Ил хаад захиран суусан ард түмнийхээ эрх ашгийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулан хоёр фронтод нэгэн зэрэг байлдаан явуулахын зэрэгцээ төрийн тусгаар тогтнолыг хангахад өрнөд Европтой холбоотны харилцаатай байхад ихэд анхаарчээ. Ил хаадын Улсын сүүлчийн хаадын үед гадаад зөрчлөө ихээхэн зөөлрүүлэх бодлого баримтлан олон улсын амьдралд энх тайвны санал, санаачлага гарган энх тунх аж төрөхийн учир холбогдлыг зарлаж байжээ. Энэ нь Иран орон төрийн нэгдлээ ханган цаашид нэгдмэл байдлаар хөгжихөд чухал нөлөө үзүүлэв.

Өөрийн хамгийн аюултай хөрш Хүлэгүгийнхний хүчийг мөхөсдүүлэх гэсэн Египедийн хүсэл эрмэлзэл болон Хүлэгүгийнхний улсаас Кавказын маргаантай газар нутгийг булааж авах гэсэн Алтан Ордны улсын чармайлт нь Египед болон Алтан Ордны улсын хооронд цэрэг дайны нэгдэл нягтралын шалтаг, өргөжих түлхэц болж өгснөөр хоёр улсын хооронд найрсаг байдал тогтон элчин харилцаа олон жилээр үргэлжлэхэд хүргэсэн.

Хан Бэрх (1256-1266 онд) Лалын шашинд орсон нь Египедийн талаас улс төрийн бодлогоо хэрэгжүүлж эхлэхэд таатай нөхцөл болж өгсөн билээ. Иймээс ч Хүлэгүгийн хүчирхэг улсын үргэлжийн заналхийлэлд өртөх болсон Египедийн султан гадаад бодлогын үндсэн чигээ Монголын захирагчдыг хооронд нь зөрчилдүүлэн дайсагналыг хөхүүлэн дэмжиж, үргэлжлүүлэн барихад хандуулан түүндээ буруу номтон (Хүлэгүгийнхэн)-ы эсрэг “ариун дайн”-нд уриалах арга мэхийг 40 жилийн турш ашиглаж чаджээ. Султан Байбарсын нарийн бичгийн дарга байсан Ибн Абд аз-Захир “султан 1261-1262 онд Бэрх ханд илгээсэн захидалдаа Бэрхийг Хүлэгүгийн эсрэг өдөөж чи лалын шашинтан тул садан төрлийг үл харгалзан буруу номтон Монголчуудтай тэмцэх нь чиний үүрэг юм гээд зөнч Мухаммедаар жишээ татаж “лалын сүсэг бол үг төдий бус ариун дайн түүний (гол) тулгуурын нэг юм” гэж захидлыг төгсгөсөн”-ийг дурьджээ. Харин Бэрхийн султанд илгээсэн нэгэн захидалд лалын шашин баримтлах болсноо онцлоод: “би Аллахын лүндэнг бүхнээс дээрд өргөж, лалын шашны номлолыг сүсэглэн Аллах болон лүндэнд үл итгэгч, үймүүлэгч, өөрийн цус махны тасархай Хүлэгүтэй тэмцэлдсэнийг султан мэдтүгэй” гээд Бэрх өөрийн төрөл садангуудаас лалын шашинд орогсдын нэрсийг тодорхой тоочин бичжээ. Ийм өнгө аястайгаар шашин нэгтнээ уяруулан ятгасан захидлууд удаа дараагаар олон жилийн туршид илгээгдсэн билээ.

Мөн Египедээс Алтан Ордны улс руу илгээсэн бэлгийн зүйлсийн дунд ямагт шашны шүтээний зүйлс⁸ тааралддаг төдийгүй мамлюк султад Алтан-Ордны улсын элчийг ихэд хүндэтгэн халифын шашны номлолд урин, Мекка болон Медин хот уруу тэднийг мөргөл үйлдэх ёслолд сэтгэл харамгүйгээр зарлагдаж Алтан Ордны улсын элчээр хэрхэн хүрээлүүлэх тал дээр онц анхаарч байсан нь тодорхой байдаг.

Харин Хүлэгүгийн улсын Токудар хан (1282-1284) дараагаар нь 1295 онд хан ширээнд өргөмжлөгдсөн Газан нь лалын шашинтай байснаар “ариун дайн”-ы учир шалтгаан нь Ил хаадын эсрэг холбоотнуудын дунд өмнөх шигээ үүрэг гүйцэтгэж чадахгүй болсон. Түүгээр ч барахгүй “ихэнх сурвалжуудад” Алтан Ордны улсын хан Токта (1290-1312) бөөгийн мөргөлтэй байсныг онцолжээ. 1304 оны 11 дүгээр сард Токтын элчийн авчирсан султаны захидалд “Газан хан бид хоёрын ажил хэргийг Аллах эвээр зохицуулсан болон Газаны дүү Харбенд (Өлзийт) найрсаг харилцааг эрхэмлэн гуйсныг дурьдсан байв” гэж аль-Макризи бичжээ. Гэхдээ лал шашинт Газан мамлюкын эсрэг дайн явуулж харин мамлюкууд Газантай дайтагч Алтан Ордоны бөө мөргөлт хан Токттай холбоотон болохыг эрэлхийлсэн адармаатай явдлаас шашин нь олон зууны турш гадаад бодлогын бодит байдлыг нуун далдлах халхавч болж байсан нь харагдаж байна.

Египед, Алтан Ордны улсын харилцаа нь Хүлэгүгийнхний Иран дахь Ээдрээтэй нарийн үйл явдлуудаар тодорхойлогдож байсан. 1313-1314 онд Алтан Ордны улсын ханаар өргөмжлөгдсөн лал шашинт Үзбек (1313-1342)-ийн үед хоёр улсын элчин харилцаа ихэд идэвхжив. Энэ үед Алтан Ордоны улс болон Египедийн хоорондын харилцаа асар их нягтарч Алтан Ордоны улсын бүх сүмд Үзбекийн нэрийн дараа султан аль-Малик ан-Насрийг дурсан түүний төлөө залбирах болжээ. Ер нь Үзбек гадаад улсуудтай дипломат шугамаар ургийн холбоо тогтоож ойртон дотносох бодлого баримталж байв. Үзбекийн хатдын нэг нь “Константинополийн эзэн”-ий охин байсан мөн өөрийн охин дүүг (Агафья хэмээн нэрлэж загалмайлсны дараа) Оросын ван Юрия Даниловичд эхнэр болгон өгсөн байв. Алтан Ордоны ба Египедийн олон жилийн найрамдал эцсийн эцэст ураг барилдахад хүрч Египедийн султан аль-Малик ан-Насир болон Бэрхийн хүү Тогаджийн охин болох Тулунби нар 1320 оны 5 дугаар сарын 16-нд гэрлэсэн билээ. Гэхдээ сүүлчийнх нь Үзбекийн талд ашигтайгаар эргэсэнгүй. Гэрлэх ёслолын дараагаар Үзбек бээр цэрэг дайны асуудал сонирхсон цэвэр ажил хэргийн элч нар илгээн “Чобаны эсрэг довтолгоонд дахин өдөөн

⁸ Султан Байбарс хан Бэрхэд халиф Осман өөрийн гараар бичсэн гэгддэг коран судрыг алтан утсаар хээлсэн улаан нүүсүүгээр хавтаслан торгоор доторлон улаан хүрэн өнгийн савхин гэрт хийж мөн энэ коран сударт зориулан мөнгөн чимэгтэй зааны яс болон хар модыг оролцуулан хийсэн тавиур, мөн хар мод, зааны яс болон мөнгө шигтгэсэн хаан ширээ дагалдуулан илгээж байжээ.

турхирах, түүний эсрэг хамтарч довтлох, бас түүний эсрэг султан, түүний цэргийг хатган хөдөлгөх” утга бүхий захидал хүргүүлсэн. Гэтэл эсрэгээр султан хоёр талт бодлогыг баримтлан Илхаадын Улсын хан Абу Саид (1316-1335)-ын амбан захирагч Чобанаас Алтан Ордоны улстай тэмцэл эхэлсэн тухай мэдээг хүлээн авмагцаа султан даруйхан Үзбекийн тусламж хүссэн тухайг түүнд мэдээлж “тэрбээр бидэнд элч зарж, Египедээс цэрэг илгээн таны эсрэг туслахыг гуйсан ч би түүнд татгалзсан хариуг” өгөв гэжээ. Ингэж хуучин холбоотон мамлюкийн Египед болон Алтан Ордоны улсын эздийн захидал харилцаанд тод ажиглагдсан хүйтэн харилцаа нь Египед-Алтан Ордон-Ил хаадын улс гэсэн гурвалжны хүчний харьцаанд үндсэн өөрчлөлт гарснаас улбаатай. Абу Сайдын лалын сүжгийн онцлол нь ердөө л султаны улс төрийн заль мэх байсан юм. Учир нь *нэгдүгээрт*, Египедэд ямар нэгэн ноцтой аюул занал учруулж чадахаа больсон Перс дэхь Ил хаад, Египедийн харилцаа зөөлөрсөн, *хоёрдугаарт*, Хүлэгүгийнхний эзэмшлийн нутгаас Алтан Ордоны улс өөртөө нэгтгэж илэрхий хүчирхэгжихээс Египедийн султан болгоомжилж байсан бөгөөд тийм хөрштэй хиллэх нь Египедэд аюултай байв. Иймээс султан Алтан Ордоны улсын хувьд дипломатын нарийн ёс журам баримтлахаа больж, элч хүлээн авах болон үдэж мордуулах сүр жавхаатай ёслол хийх, мөн үнэтэй бэлэг сэлт илгээх зэргээ зогсоожээ. Гэхдээ энэ хоёр төр баригчид элчин харилцаагаа сэргээсэн ч ихэнхдээ гүнж Туланбигийн хувь заяаны талаарх ноцтой асуудлыг хөндөж байсан билээ.

Үзбекийн дараа 1341-1342 онд Жанибек нь хан ширээнд суух үедээ Египедтэй элчин харилцааг үргэлжлүүлсэн. Гэхдээ Жанибекийн үед Алтан Ордны улс болон Египедийн хоорондын харилцаа өмнөх шиг эрчимтэй байгаагүй нь *нэгдүгээрт*, Ил хаадын улсын хүч суларсан, *хоёрдугаарт*, 1345-1350 онд Өрнө болон Дорныг бүхэлд нь хамарсан “хар үхэл” гэж нэрлэгдсэн тахал нь 1347 онд Алтан Ордны улсад дараа нь Крымд, тэндээсээ дорно зүг үрүү чиглэн 1348-49 онд Египедэд тархсантай зарим талаар холбоотой юм. Азербайжаныг эзлэн авах алтанордоныхны эртний мөрөөдөл Жанибекийн хаанчлалын үед л биелэлээ олжээ. 1357 онд Жанибек Азербайжан руу хөдөлж Ираны хойд нийслэл Тебризийг эзлэн авсан⁹. Алтан Ордоны улсын хан энэ тухайгаа Египедийн султан ал-Малик ан-Насир Хасанд (хоёрдахь хаанчлалын үе нь 1354-1361 он) мэдээлэхийг тун яаравчилжээ. Эл зорилгоор илгээсэн элч нар 1357 оны зуны эцсээр Египедэд хүрэлцэн очжээ. Жанибек

⁹ Тахлын уришгаас Алтан Ордоны улс удаан хугацааны турш тэнхэрч чадахгүй байлаа. Зөвхөн Жанибекийн хаанчлалын сүүлийн жилүүдэд л Хүлэгүгийнхэнтэй Кавказад дахин үргэлжлүүлэн дайтах чадалтай болж Азербайжаныг түр зуур өөртөө нэгтгэсэн билээ.

захидалдаа Малик-Ашрафыг ялсан ялалтынхаа тухай султанд мэдээлээд заншсан ёсоор элчээрээ боолууд, булганы арьс болон махчин шувууд бэлэг хүргүүлсэн.

Аль-Макризийн үгээр Алтан Ордоны улсын элч нарыг маш сүржин хүндэтгэлээр тосож: “тэднийг эмир, мамлюкууд, цэргийн дарга нар, цэргүүдээс бүрдсэн их жагсаалаар угтан авчээ”. Аль-Асади бээр нэмж “Элч нарын хүрэлцэн ирсэн өдөр баярын өдөр байсан гэж бичээд бүх дайчдад алтан хатгамалтай хувцас, алтадмал малгайгаа өмсөж, бүрэн зэвсгээ агссан байх үүрэг болгосон. Мөн түүнчлэн тэднийг [элч нар] Египедэд байх үед асар ихээр халамжлан хүндэтгэл үзүүлж байсан” гэжээ. Элчийг угтаж зохион байгуулсан султаны цэргийн жагсаалын хариу болгох мэт Алтан Ордоны улсын элч нар өөрийн улсын цэргийн сүр хүчийг гайхуулах зорилгоор өөрсдийн эзэн захирагчийн байгуулсан ялалтуудыг нилээд хэтрүүлэгтэйгээр мэдээлж байжээ. Ингэж хоёр улс хамтран Хүлэгүгийн улсын эсрэг Ариун дайн явуулахыг бие биедээ уриалж байсан ч энэ нь бодит байдал дээр биелэгдэж байгаагүй билээ.

Жанибекийг түүний хүү Бердибек залгамжлан хан ширээнд 3 жил суухдаа Египедтэй харилцаж байсан тухай ямар ч мэдээ байдаггүй. Түүний үхлийн дараа Алтан Ордон улсын дотоодын тэмцэл дахин хурцдаж 20 жилийн хугацаанд 25 хан солигдсон байна. Харин 1380 онд Алтан ордоны улсын ханаар Тохтамыш тодорч улсаа дахин хүчирхэг болгохыг чармайснаар хоёр улсын хоорондын элчин харилцаа ч сэргэсэн. Гэвч тэдний аль алинд заналхийлэх болсон доголон Төмөрийн Алтан Ордон улс уруу чиглэсэн халдан довтлолтоос айн сандарч тус улсаас даруй хөдөлж 1395 оны 9 дүгээр сарын 18-нд Египедэд буцаж очсон султаны элч нар хамгийн сүүлчийнх байсан билээ. Доголон Төмөрийн халдалтууд онцолвол 1395 оны хүчтэй цохилтын дараа Алтан Ордон улс нь хагас зууны турш оршин тогтносон шигээ тийм хүчирхэг том улсыг төлөөлж чадахаа больж өөр улсууд ялангуяа Египедтэй явуулах дипломат харилцаа нь хумигджээ.

Хоёр улсын хоорондын харилцааны явцад мэдээж хэрэг харилцан үл ойлголцол болон янз бүрийн зөрчил гарч болох байсан, үнэхээр үүсэн гарч ч байсан. Жишээлбэл, Иран уруу хамтран довтлох Токта болон Үзбекийн хүсэлтээс Египед татгалзсан болон Султан аль-Малик ан-Насир бээр Чингисийн удмын гүнж Тулунбигаас гэрлэлтээ цуцлан салсан, улмаар гуравдагч орнуудтай үл ойлголцох байдал (ялангуяа Византи улс) гэх мэт нь зөрчилдөөний шалтаг болж байжээ. Гэсэн ч Алтан Ордоны улсын Египедтэй тогтоосон элчин харилцаа нь 200 орчим жил үргэлжилж 50 орчим удаагийн элч төлөөлөгчид харилцан солилцож байсан билээ.

Алтан Ордны, Египед болон Хүлэгүгийнхний Иран гэсэн гурвалжинд эхний хоёрын сүүлчийнх рүүгээ чиглэсэн дайсагнал нь түүний өндөрлөг нь болж байсан ч Алтан Ордон, Египедийн харилцаа холбоонд өөр шалтгаан байсныг үгүйсгэж болохгүй. XIII зуунд хүн төрөлхтний бүх л ололт амжилтуудыг өөртөө шингээсэн Дорно дахины соёл тэргүүлж байсан бөгөөд Алтан Ордны улс, Египедийн хоорондын дипломат харилцааны гадаад төрх байдал, ёс журмыг нөхцөлдүүлж өгсөн. Энэ бүх зан үйл, заншил нь Египедэд ч Алтан Ордны улсад ч жинхэнэ ур чадвараар гүйцэтгэгдэх дипломат ёслолын чухлыг (эрхэм байдлыг) онцлон харуулах нэг л зорилготойгоор үйлчилж байв.

Илгээж буй хаадын нэр сүрийг илтгэсэн дипломат илгээлтийн гадаад гоёмсог байдлын зэрэгцээ элчийг хүлээн авах баяр ёслолын тансаг байдал, элчийн хэргэм зэргээс хамаарах хүндэтгэл зэрэг нь хоёр улсын дипломатын ур чадварыг илтгэж байв. Үүнтэй холбогдуулан нэгэн жишээ дурьдахад хилийн харуулд хан Тохтамышийн элч гэж өөрийгөө мэдэгдэн нэг элч Египедэд хүрэлцэн очжээ. Энэ мэдээ Кайрт хүрэнгүүт Египедийн султан найрсаг харилцаат Алтан Ордны улсын хааны элчийг ихэд хүндэтгэн дээд албаны түшмэдээ угтуулан илгээжээ. Ингээд ханг ихэд эрхэмлэн түүний элчийг хамгийн нэр хүндтэй зочдын “Том майдан”-д байрлуулав. Төрийн бичиг хэрэг эрхлэх газрын дарга аль-Бадр ад-дин ибн Фадлаллах ал-Умари захидлыг элчээс гардан авах үедээ ихэд ажиглан илгээмж(жуух бичиг)-ийн “цаасны хэмжээ болон найруулга зэрэг нь хангийн захидлын тогтсон зарчимтай тохирохгүй” байгааг олж мэдсэн. Тэрбээр тухайн элчээс тайлбарыг шаардахад Тохтамышийн Крым дэх амбан захирагч илгээснийг хүлээн зөвшөөрсөн байна. Ал-Бадр ад-дин бээр элчийн энэ үйлдэлд ихэд дургүйцэн зэвүүцэж илгээсэн эзнийх нь зиндаанд тохируулан хүлээн авалтыг өөрчлөхийг тушааж байсан байдаг.

Дипломат бичиг эрхлэлтийн нарийн төвөгтэй байдал нь ордны тохирох төрийн түшмэдийг, ялангуяа төрийн нарийн бичгийн даргыг¹⁰ сонгохыг шаарддаг байсан бөгөөд тэдний бүтээл хамгийн дээгүүр үнэлэгдэж байсан юм. Алтан Ордны улсын төрийн бичиг эрхлэх газарт захидлыг монгол хэлээр төдийгүй араб, түрэг, перс, уйгур, орос хэлээр явуулж байсан. Иймээс ч Алтан Ордны улсын зарим хаад өөрсдийнхөө гарлаар бахархан Египедийн султанд эх монгол хэлээрээ захидал бичин илгээж байжээ. Харин Египедийн

¹⁰ Тэдний талаар Хиндушах бээр өгүүлэхдээ “Суут алдар ба нэр хүндийн оргилд хүрэх, төгс төгөлдөрийн өндөрлөгийг эзэмших, дэлхийг эзэрхэх шатаар өөд гарах, засгийн дээд эрхийг шүүрч авах явдлыг өндөр зоригор хэрэгжүүлэхэд төрийн нарийн бичгийн даргын өндөр албан тушаалд тохирохуйц бичгийн хүнийг томилон хэрэглэснээр биеллээ олно” мөн энэ албан тушаалтан “засаглал ба улс орны байдлын нууцыг” хадгалах ёстой, “үзгийн оролцоогүйгээр улс гүрэнд дэг журам тогтдоггүй учраас тэрбээр гайхалтай чадварлаг найруулан бичлэгийн түлхүүр, гайхамшигтай, ховор төгөлдөр хэллэгийн эзэн” байх ёстой байв гэсэн байдаг.

сулсад өөрсдийн илгээсэн захидлынхаа утга санааг хантаны орчуулагчид буруу орчуулахаас зайлсхийх үүднээс ханд ойлгомжтой хэлээр харилцаж байхын тулд өөрсдийн ордонд монгол хэл гаргуун эзэмшсэн тусгай орчуулагч-захидал хөтлөгчтэй байсан. Жишээлбэл, Жанибек хантай захидал харилцааг монгол хэлээр хөтлөн явуулах үүргийг Итмыш ал-Мухаммад, Таирбуга ан-Насир болон хэлмэрч Аргадаг зэрэг хэд хэдэн хүн хүлээж байв. Бидний мэдэхээр мамлюк эмир Ардаш Чингис хааны цааз бичиг “Их Засаг” хууль, татаарын угын бичгийг хичээнгүйлэн судалсан байжээ. Дипломат бичиг эрхлэлт болон илгээмжийн хэлбэр маяг зэрэг нь соёл, боловсролын бүрэлдэхүүн хэсгийн нэг, зарим талаараа тэр үеийнхээ шинжлэх ухааны ололт амжилт болж байсан гэдгийг харуулж байна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд Монголын эзэнт гүрний өргөн уудам нутаг дэвсгэр нь гадаад бодлогынхоо чиг шугамыг шуурхай зохицуулах ажилд зохих хэмжээний хүндрэл учруулах болсон. Иймээс эзэнт гүрний Засгийн газар орон нутгийн засаг захиргаанд гадаад харилцааны талаар зохих хэмжээний эрх мэдлийг олгохоос өөр аргагүй болсон билээ. Тухайлбал, Ил хаадын улс нь өмнөд ба баруун Европ, Хойд Африк, Ойрхи Дорнод руу чиглэсэн бодлогыг, Алтан Ордоны улс нь Төв Европ ба Балканы хойг болон руу чиглэсэн бодлогыг төвөөс өгсөн гадаад бодлогын чиглэлийн дагуу гардан хэрэгжүүлж байсны зэрэгцээ улсынхаа тусгаар тогтнолоо хамгаалсан, эсвэл өөрсдийн эрх ашгаа эрхэмлэсэн бие даасан гадаад бодлогыг идэвхтэй явуулж байв. Ингэхдээ харь орнуудад очиж суусан Монгол хаад Чингисийн үеэс үүсгэн явуулж агсан гадаад бодлого, дипломатын арга ажиллагааны ёс журмыг чанд журамлан тус тусынхаа захиран сууж буй улсын гадаад харилцааны хэргийг хөтлөн явуулж байсан бөгөөд Хятад, Лалын шашинт улсууд, Орос зэрэг монголд эзлэгдэж байсан улсуудын түүхээс үзэхэд XIII зуунаас хойш эдгээр улсуудын төрийн байдал урьдынхаасаа илүү тогтвортой болсон нь ажиглагддаг.

Ашигласан материал:

1. Ж. Бор. “Монгол хийгээд Евразийн дипломат шастир” -II боть. Улаанбаатар, 2004
2. С. Салих Закиров. “Алтан Ордоны улсаас Египедтэй барьж байсан дипломат харилцаа /XIII-XIV зуун/”. Монгол орчуулга. С.Оюунсүрэн, Улаанбаатар, 2004
3. Рювен Амитай. “Монголчууд ба Мамлюкууд: Мамлюк, Ил хаадын дайн /1260-1281/”. Монгол орчуулга. С.Оюунсүрэн, Улаанбаатар, 2006
4. Рашид ад-Дин. “Судрын чуулган”, Монгол орчуулга. Ц. Сүрэнхорлоо, Улаанбаатар, 2002
5. В.В. Бартольд. Искусство мусульманства. Москва
6. Ж. Баясах. “Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг”. Улаанбаатар, 2005
7. ОУХС-иас эрхлэн гаргасан: “Алтан Аргамж” сэтгүүл, No 2. Улаанбаатар, 1998
8. Д.Уламбаяр. Монгол, Өрнөдийн харилцаа: эрт, эдүгээ. Улаанбаатар, 2004